




СОЁЛЫН ЯАМ







МОНГОЛЫН
ҮНДЭСНИЙ
КИНО УРЛАГИЙН
ЗӨВЛӨЛ

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНД ТӨСӨЛ МЭДҮҮЛЭГЧИД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

(ТӨСЛИЙН ТӨРӨЛ: ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ХҮСЭХ)

Төслийн төрөл: ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ХҮСЭХ

№1	КИНО УРЛАГИЙН ДЭМЖИХ САНГИЙН СИСТЕМД НЭВТРЭХ
1.1	<p>1. Кино урлагийг дэмжих санд төсөл илгээхдээ www.kuds.filmmongolia.gov.mn хаягт хандан хувь хүн эсвэл албан байгууллагаар бүртгэл үүсгэн системд нэвтэрч төсөл мэдүүлнэ.</p> <p>2. Кино урлагийг дэмжих сангийн системд бүртгэлээр нэвтрэн орсны дараа “ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ХҮСЭХ” гэсэн формыг сонгож орно.</p> <div data-bbox="440 682 1404 829" style="text-align: center;">  ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ  </div> <p>3. “ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ХҮСЭХ” форм руу орж “+ Нэмэх” гэсэн товчийг дарснаар төслийн хүсэлт илгээх талбарууд гарч ирнэ.</p> <div data-bbox="618 934 1291 1071" style="text-align: center;">  + Нэмэх  </div>
№2	“ЗЭЭЛИЙН ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага
	<p>Эргэн төлөгдөх нөхцөлтэй хөнгөлөлттэй зээл хүсэх форумын “Зээлийн хүсэлт гаргагчийн мэдээлэл” талбарт дараах 2 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Өргөдөл / Албан бичиг • Иргэний үнэмлэхийн хуулбар / Байгууллагын гэрчилгээний хуулбар (<i>Та хувь хүнээр төсөл мэдүүл буй тохиолдолд өөрийн иргэний үнэмлэхийн цахим хуулбарыг файлаар хавсаргана. Хэрэв албан байгууллагаар мэдүүлж буй тохиолдолд тухайн байгууллагын гэрчилгээг хавсаргана.</i>)
2.1	<p style="text-align: center;">ӨРГӨДӨЛ / АЛБАН БИЧИГ</p> <p>Тухайн төсөл, арга хэмжээ нь “Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банкинд тавих шалгуур, банкиг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журам” -ын 1.4-д заасан зөрчилгүй, 2.3-д заасан чиглэлүүдийн аль нэг зүйлд нийцэж буйг өргөдөлдөө сайтар тусгасан байна. Мөн төслийн хэрэгжүүлэлтийн аль үе шат, үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг шаардлагатай байгааг бичиж, Кино урлагийг дэмжих сангаас хүсэж буй санхүүжилтийн хэмжээ, тус</p>

	<p>үнийн дүн нь төслийн нийт төсвийн хэдэн хувь болохыг дурдсан байна. Мөн тухайн кино бүтээл / техник технологи, инноваци нэвтрүүлэх төслийн албан ёсны эрх эзэмшигч хувь хүн аль эсвэл хуулийн этгээдийг тодорхой заасан байна.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо: 150-300</p>
<p>2.2</p>	<p align="center">ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН ХУУЛБАР / БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР</p> <p>Та хувь хүнээр төсөл мэдүүл буй тохиолдолд өөрийн иргэний үнэмлэхийн цахим хуулбарыг файлаар хавсаргана. Хэрэв албан байгууллагаар мэдүүлж буй тохиолдолд тухайн байгууллагын гэрчилгээний хуулбар (нүүр болон ар тал)-ыг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
<p>№3</p>	<p align="center">“ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага</p>
<p>3.1</p>	<p align="center">“ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ” талбарын “Төслийн төрөл” хэсгээс “КИНО БҮТЭЭХ” төслийн төрлийг сонгосон тохиолдолд доор дурдсан файлуудыг бэлтгэн хавсарган ирүүлнэ.</p>
	<p>“Эргэн төлөгдөх нөхцөлтэй хөнгөлөлтэй зээл хүсэх” санхүүжилт форумын “Төслийн ерөнхий мэдээлэл” талбарын “Кино бүтээх” төрөлд дараах 12 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Кино төслийн товч танилцуулга • Кино зохиолын хураангуй • Найруулагчийн танилцуулга • Продюсерын танилцуулга • Кино төсөл хэрэгжүүлсэн туршлагын мэдээлэл • Төслөөс гарах үр дүнгийн урьдчилсан төсөөлөл • Оюуны өмчийн баталгаа • Төсөлд шаардлагатай патент, лиценз • Зохиолчийн үзэл баримтлал • Найруулагчийн үзэл баримтлал • Продюсерын үзэл баримтлал • Бусад
<p>3.1.1</p>	<p align="center">КИНО ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</p> <p>Кино төслийн товч танилцуулгад дараах мэдээллүүдийг багтаасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн нэр :

- Төрөл :
- Үргэлжлэх хугацаа :
- Хэл :
- Кино зохиолын logline :
- Продакшн компани :
- Нийт төсөв /төгрөгөөр/ :
- Кино бүтээх хугацаа :
- Бэлэн болох хугацаа :
- Кино төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг дараах хүснэгтийн дагуу хийж ирүүлнэ үү.

Хүснэгт. Кино төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Төслийн үе шат	Хийгдэх ажлууд	Байршил	Оролцох уран бүтээлчид	Хугацаа	
					Эхлэх	Дуусах
1	Хөгжүүлэлт /development/					
2	Зураг авалтын өмнөх шат /pre-production/					
3	Зураг авалтын шат /production/					
4	Зураг авалтын дараах шат /post-production/					
5	Түгээлт /distribution/					

Хавсаргах файлын төрөл: PDF

3.1.2

КИНО ЗОХИОЛЫН ХУРААНГУЙ

Synopsis /анотаци/ буюу киноны зохиолын богино танилцуулга байна. Кино зохиолын богино танилцуулгад харилцан яриаг огт оруулахгүйгээр зөвхөн үйл явдлыг нь дүрслэн бичихийг анхаарна уу.

Хавсаргах файлын төрөл: PDF

Үгийн тоо: 500-800

3.1.3

НАЙРУУЛАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн киноны ерөнхий найруулагчийн танилцуулга (сүүлийн 5 жилийн кино бүтээл, гаргасан амжилтын мэдээлэл) байна. Үүнд:

- Боловсролын мэдээлэл /төгссөн их, дээд сургууль болон кино урлагийн чиглэлээр суралцсан богино хугацааны сургалт/,
- Ажлын туршлагын талаарх мэдээлэл /ажиллаж байсан байгууллага болон эрхэлсэн албан тушаалын мэдээлэл/
- Найруулагчаар ажилласан кино бүтээлүүдийн жагсаалт /богино болон бүрэн хэмжээний кино бүтээл/,

	<ul style="list-style-type: none">Шагналын тухай мэдээлэл /кино бүтээлийн шагнал болон бусад гавьяа шагнал/ <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.1.4	<p style="text-align: center;">ПРОДЮСЕРИЙН ТАНИЛЦУУЛГА</p> <p>Төслийн киноны ерөнхий продюсерын танилцуулга (сүүлийн 5 жилийн кино бүтээл, гаргасан амжилтын мэдээлэл) байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">Боловсролын мэдээлэл /төгссөн их, дээд сургууль болон кино урлагийн чиглэлээр суралцсан богино хугацааны сургалт /,Ажлын туршлагын талаарх мэдээлэл /ажиллаж байсан байгууллага болон эрхэлсэн албан тушаалын мэдээлэл/Продюсероор ажилласан кино бүтээлүүдийн жагсаалт /богино болон бүрэн хэмжээний кино бүтээл/,Шагналын тухай мэдээлэл /кино бүтээлийн шагнал болон бусад гавьяа шагнал/ <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.1.5	<p style="text-align: center;">КИНО ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТУРШЛАГЫН МЭДЭЭЛЭЛ</p> <p>Өмнө хэрэгжүүлж байсан ижил төстэй кино төслийн товч танилцуулга, кино багийн танилцуулга, түгээлтийн мэдээлэл (ашиг орлогын мэдээллийг багтаасан) зэргийг багтаасан товч танилцуулгыг илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.1.6	<p style="text-align: center;">ТӨСЛӨӨС ГАРАХ ҮР ДҮНГИЙН УРЬДЧИЛСАН ТӨСӨӨЛӨЛ</p> <p>Тухайн киноны дотоод, гадаадын кино зах зээлээс олох ашиг орлогын урьдчилсан тооцоолол, монгол киноны урлагт оруулах хувь нэмэр, төслийн хүрээнд кино урлагийн уран бүтээлчид болон дагалдах салбарын хэдэн ажилчдыг дадлагажуулах, гэрээт ажлаар хангах зэрэг төслийг хэрэгжүүлснээр гарах нийгэм, эдийн засгийн үр нөлөөг бичнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.1.7	<p style="text-align: center;">ОЮУНЫ ӨМЧИЙН БАТАЛГАА БОЛОН ЗӨВШӨӨРӨЛ АВСАН ЭСЭХ</p> <p>Хэрэв ТИЙМ гэсэн сонголтыг хийж байгаа бол тухайн бүтээлийн оюуны өмчийн гэрчилгээг файлаар хавсаргана. ҮГҮЙ гэсэн сонголтыг хийж буй тохиолдолд гарч ирэх 2 сонголтод сэдэвлэсэн зохиол бол эх зохиолчоос авсан зөвшөөрлийг файлаар хавсаргах, эсвэл тухайн киноны зохиолч оюуны өмчийн зөрчилгүй гэсэн мэдэгдлийг Монголын үндэсний кино урлагийн зөвлөлд хандсан алба бичиг хэлбэрээр файлаар хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>



3.1.8	<p style="text-align: center;">ТӨСӨЛД ШААРДЛАГАТАЙ ПАТЕНТ, ЛИЦЕНЗ</p> <p>Мэдүүлж буй кино төсөлтэй холбоотой патент, лицензийн бичиг баримт байгаа бол хавсарган илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.1.9	<p style="text-align: center;">НАЙРУУЛАГЧИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ</p> <p>Найруулагчийн хувиар тухайн киног найруулах болсон шалтгаан, кино зохиолын санаа, өгүүлэмжтэй ямар холбоо хамааралтай болох зэргийг бичихээс гадна найруулгын уран сайхны шийдлийн илтгэсэн дараах зүйлсийг хавсаргасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тухайн найруулагч киногоо бүрэн илэрхийлсэн зурган дүрслэлийн цуглуулга (MOOD BOARD) /жишээ/ • Хөгжмийн санаа /жишээ/ • Зурган өгүүлэмж (Storyboard / раскадровка) - <i>тухайн кино төслийн “Зураг авалтын бэлтгэл үе шат” хийгдсэн тохиолдолд зурган өгүүлэмжийг хэсэгчлэн ирүүлнэ /</i> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо : 350-500</p>
3.1.10	<p style="text-align: center;">ЗОХИОЛЧИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ</p> <p>Зохиогчийн хувиар кино зохиолын үүдэл санаа юунаас үүдэлтэй, зохиолын сэдэв, агуулгыг хэрхэн боловсруулсан зэргийг бичихээс гадна тухайн кино зохиол сэдэвлэсэн зохиол эсэх, зохиолын бичилтийн хэд дэх хувилбар, кино зохиол хөгжүүлэгчээс зөвлөгөө авч засварласан эсэх зэрэг нэмэлт мэдээллээ бичиж ирүүлнэ. Мөн тухайн кино зохиол оюуны өмчийн зөрчилгүй болохыг зохиолчийн хувиар илэрхийлсэн байна.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо : 350-500</p>
3.1.11	<p style="text-align: center;">ПРОДЮСЕРЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ</p> <p>Продюсерын хувиар кино зохиолоос юу анхаарал татсан болох, зохиолын санаатай ямар нэг байдлаар хамааралтай эсэх, тус кинонд продюсероор ажиллах болсон шалтгаан, найруулагчийн чадварт хэрхэн итгэж буй, тус киног бүтээх нь ямар ач холбогдолтой, үзэгчдэд хүргэх гол санаа юу болох зэргийг бичихээс гадна кино бүтээлийн уран сайхны болон арилжааны чадамжийг хэрхэн үнэлж, тодорхойлж буйгаа бичнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо : 350-500</p>



3.1.12	<p style="text-align: center;">БУСАД</p> <p>Кино төсөлтэй холбоотой нэмэлт мэдээлэл (кино наадмаар түгээх төлөвлөгөө, маркетингийн төлөвлөгөө гэх мэт) -ийг илгээнэ. Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.2	<p style="text-align: center;">“ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ” талбарын “Төслийн төрөл” хэсгээс “КИНО ҮЙЛДВЭРЛЭЛ” төслийн төрлийг сонгосон тохиолдолд доор дурдсан файлуудыг бэлтгэн хавсарган ирүүлнэ.</p>
	<p>“Эргэн төлөгдөх нөхцөлтэй хөнгөлөлтэй зээл хүсэх” санхүүжилт форумын “Төслийн ерөнхий мэдээлэл” талбарын “Кино үйлдвэрлэл” төрөлд дараах 4 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн танилцуулга • Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлагын мэдээлэл • Төслөөс гарах үр дүн, нийгэм эдийн засгийн ач холбогдол, дэвшилтэт тал • Бусад
3.2.1	<p style="text-align: center;">ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА</p> <p>Тухайн төслийг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага, сэдвийн судалгаа, шинжилгээ, төслийн зорилго, хамрах хүрээ, төсөл хэрэгжсэнээр Монголын кино урлагийн салбарт оруулах үр өгөөж, ач холбогдолыг тусгасан товч танилцуулгыг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо : 500-800</p>
3.2.2	<p style="text-align: center;">ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТУРШЛАГЫН МЭДЭЭЛЭЛ</p> <p>Өмнө хэрэгжүүлж байсан ижил төстэй кино төслийн товч танилцуулга, төслийг хэрэгжүүлсэн баг бүрэлдэхүүний мэдээлэл, төслийн хамрах хүрээ, оролцогчид, төслийн хүрсэн үр дүн, ашиг орлого зэрэг мэдээллийг багтаасан байна.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
3.2.3	<p style="text-align: center;">ТӨСЛӨӨС ГАРАХ ҮР ДҮН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ, ДЭВШИЛТЭТ ТАЛ</p> <p>Тухайн төсөл хэрэгжсэнээр хүлээгдэж буй үр дүн, шинэлэг тал, практик ач холбогдол, ашиг орлогын тооцоолол, төслийн үр дүнг ашиглах боломжит чиглэлүүд зэрэг нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тодорхой дурдсан байна.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо : 300-500</p>


3.2.4	<p style="text-align: center;">БУСАД</p> <p>Төсөл, арга хэмжээтэй холбоотой үйл ажиллагааны талаарх нэмэлт мэдээллийг хавсарган илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
№4	“ТӨСЛИЙН ЗАХ ЗЭЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ТООЦООЛОЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага
	<p>“Эргэн төлөгдөх нөхцөлтэй хөнгөлөлтэй зээл хүсэх” санхүүжилт форумын “Төслийн зах зээл, эдийн засгийн судалгаа, тооцоолол” талбарт дараах 6 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Гадаад, дотоод орчны шинжилгээ (SWOT)• Төслийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх судалгаа• Даатгалд хамрагдах тооцоолол• Хөрөнгө оруулалт, зээлийн зарцуулалтын тооцоо• Кино түгээлт, борлуултын орлого, төслийн үр ашиг болон хөрөнгө оруулалтыг нөхөх хугацааны тооцоолол• Бусад
4.1	<p style="text-align: center;">ГАДААД, ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ (SWOT)</p> <p>Тухайн төсөл хэрэгжүүлэх байгууллага нь давуу тал, сул тал, учирч болзошгүй аюул, эрсдэл болон боломж, төсөл хэрэгжүүлэх суурь гадаад орчны хүчин зүйлсийг ангилж, хандлагыг тодорхойлсон иж бүрэн шинжилгээг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
4.2	<p style="text-align: center;">ТӨСЛИЙН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУДАЛГАА</p> <p>Тухайн төсөл хэрэгжүүлэхэд учирч болзошгүй нийгэм, эдийн засгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх судалгаа, авч хэрэгжүүлэх арга хэмжээг дурдсан байна.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
4.3	<p style="text-align: center;">ДААТГАЛД ХАМРАГДАХ ТООЦООЛОЛ</p> <p>Тухайн төслийн үйл ажиллагааны хүрээнд хамрагдах даатгалын тооцооллыг гаргаж ирүүлнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
4.4	<p style="text-align: center;">ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЗЭЭЛИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО</p> <p>Төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, зээлийн зарцуулалтын тооцоолол гаргаж ирүүлнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>

<p>4.5</p>	<p align="center">КИНО ТҮГЭЭЛТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, ТӨСЛИЙН ҮР АШИГ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НӨХӨХ ХУГАЦААНЫ ТООЦООЛОЛ</p> <p>Кино бүтээх төсөл мэдүүлж буй тохиолдолд дотоод, гадаадын кино зах зээлд түгээх төлөвлөгөө, ашиг орлогын урьдчилсан тооцоолол, кино үйлдвэрлэлийн төслийн бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө, борлуулалт ашиг орлогын тооцооллыг гаргаж ирүүлнэ. Мөн хөрөнгө оруулалтыг нөхөх хугацааны тооцооллыг гаргасан байна.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF Үгийн тоо : 350-500</p>
<p>4.6</p>	<p align="center">БУСАД</p> <p>Тухайн төслийн зах зээл, эдийн засгийн судалгаа, үр ашгийн тооцоололтой холбоотой нэмэлт мэдээллийг хавсарган илгээнэ.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
<p>№5</p>	<p align="center">“ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ” талбарт хавсаргах материалд тавигдах шаардлага</p>
	<p>“Эргэн төлөгдөх нөхцөлтэй хөнгөлөлтэй зээл хүсэх” санхүүжилт форумын “Төслийн зээлийн мэдээлэл” талбарт дараах 6 материалыг файлаар хавсарган илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх болон эзэмших улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар • Үл хөдлөх эд хөрөнгө барьцаанд байгаа эсэх лавлагаа • Зээлийн хэвийн үлдэгдэлтэй эсэх • Байгууллагын сүүлийн 2 жилийн санхүүгийн баталгаажсан тайлан • Байгууллага шинээр байгуулагдсан бол эхлэлтийн тайлан • Байгууллагын сүүлийн 2 жилийн татварын тодорхойлолт
<p>5.1</p>	<p align="center">ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ӨМЧЛӨХ БОЛОН ЭЗЭМШИХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР</p> <p>Мэдүүлж буй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх болон эзэмших улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
<p>5.2</p>	<p align="center">ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ БАРЬЦААНД БАЙГАА ЭСЭХ ЛАВЛАГАА</p> <p>Мэдүүлж буй үл хөдлөх эд хөрөнгө барьцаанд байгаа эсэх лавлагааг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>



5.3	<p align="center">ЗЭЭЛИЙН ХЭВИЙН ҮЛДЭГДЭЛТЭЙ ЭСЭХ</p> <p>Монгол банкны мэдээллийн санд зээлийн хэвийн үлдэгдэлтэй бол ТИЙМ хэрэв зээлийн үлдэгдэлгүй бол ҮГҮЙ сонголтыг хийн цааш үргэлжлүүлнэ үү. Хэрэв “Тийм” гэсэн сонголтыг хийсэн бол “Зээлийн гэрээ” болон “Зээлийн дансны баталгаажсан хуулга”-ыг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
5.4	<p align="center">БАЙГУУЛЛАГЫН СҮҮЛИЙН 2 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН БАТАЛГААЖСАН ТАЙЛАН</p> <p>Төсөл мэдүүлэгч хуулийн этгээдийн сүүлийн 2 жилийн санхүүгийн баталгаажсан тайлангийн хуулбарыг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
5.5	<p align="center">БАЙГУУЛЛАГА ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН БОЛ ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН</p> <p>Төсөл мэдүүлэгч байгууллага шинээр байгуулагдсан тохиолдолд санхүүгийн эхлэлтийн тайлангийн хуулбарыг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>
5.6	<p align="center">БАЙГУУЛЛАГЫН СҮҮЛИЙН 2 ЖИЛИЙН ТАТВАРЫН ТОДОРХОЙЛОЛТ</p> <p>Төсөл мэдүүлэгч байгууллагын сүүлийн 2 жилийн татвар төлснийг гэрчлэх тодорхойлолтыг хавсаргана.</p> <p>Хавсаргах файлын төрөл: PDF</p>

ЖИЧ :

1. “ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ХҮСЭХ” -ийн төслийн мэдүүлэгт хавсаргах файлуудад энэхүү зөвлөмжид заасан холбогдох агуулгыг боловсруулан бэлтгэж, стандартыг мөрдөж шаардлага хангасан, үнэн бодит мэдээлэлтэй материал илгээх ёстойг анхаарна уу.
2. Дараах талбаруудыг бөглөхдөө  тэмдэг дээр дарж гарч ирэх хүснэгтэд холбогдох мэдээллийг бичнэ. Үүнд:
 - “Төслийн ерөнхий мэдээлэл” талбарын “Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Төсөл хэрэгжүүлэх эд хөрөнгийн мэдээлэл”
 - “Төслийн зах зээл, эдийн засгийн судалгаа, тооцоолол” талбарын “Кино төслийн үйлдвэрлэлийн зардлын тооцоо”
 - “Төслийн зээлийн мэдээлэл” талбарын “Зээлд барьцаалах үл хөдлөх эд хөрөнгийн мэдээлэл” хэсгүүд болно.

Жишээ нь:



СОЁЛЫН ЯАМ

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНД ТӨСӨЛ
МЭДҮҮЛЭГЧИД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ



Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө



Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө



Ажлын нэр

Хариуцагчийн мэдээлэл

Enter something...

Эхлэх хугацаа

Дуусах хугацаа

Байршил

Enter something...

Хадгалах

Шинээр бөглөх

3. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВ

Төслийн мэдүүлэг бөглөх явцад “Баталгаажуулалтын төлөв” хэсгийн “Хадгалаад засварлах / Update” төлөвийг сонгон “Хадгалах” товчийг дарж системд оруулсан мэдээллээ хадгална. Мэдүүлгийн бүх тайлбарыг бөглөж дууссаны дараа тухайн хэсгийн “Баталгаажуулж илгээх/ Submit” төлөвийг сонгож “Хадгалах” товчийг дарж төслөө илгээнэ.

Баталгаажуулж илгээх / Submit

Хадгалаад засварлах / Update

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ



+976 (51) 262226
www.kuds.filmmongolia.gov.mn
Mongolian National Film Council